

2024 он 04 сар 25 өдөр

№ 24/05

Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Ард Лизинг ХХК-ийн ТУЗ-ийн гишүүдийг томилох тухай

Компанийн тухай хуулийн 76-р зүйл, Компанийн Дүрэм болон 2024 оны 4 сарын 25-ны Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ээлжит хурлын шийдвэрийн дагуу

ТОГТООХ НЬ:

Дараах этгээдийг Ард Лизинг ХХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдээр 2024 оны 5 сарын 1-нээс эхлэн **ТОМИЛСУГАЙ**:

1. Чулууны Ганхуяг;
2. Батбилэгийн Золбоо;
3. Ганхуягийн Билгүүн;
4. Гүррагчаагийн Сүхбаатар;
5. Мөнхбатын Мөнх-Эрдэнэ.

ДАРГА



Ч.ГАНХУЯГ

2024 он 04 сар 25 өдөр

No. 24/06

Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

*Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Нарийн
Бичгийн Дарга томилох тухай*

Компанийн тухай хуулийн 76-р зүйл, Компанийн Дүрэм болон 2024 оны 4 сарын 25-ны Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ээлжит хурлын шийдвэрийн дагуу

ТОГТООХ НЬ:

Сүхчулууны Нямгэрэлийг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Нарийн Бичгийн Даргаар 2024 оны 5 сарын 1-нээс эхлэн **ТОМИЛСУГАЙ**.

ДАРГА



Ч.ГАНХУЯГ

2024 он 04 сар 25 өдөр

№. 24/07

Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Гүйцэтгэх захирал томилох тухай

Компанийн тухай хуулийн 76-р зүйл, Компанийн Дүрэм болон 2024 оны 4 сарын 25-ны Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ээлжит хурлын шийдвэрийн дагуу

ТОГТООХ НЬ:

Гүйцэтгэх Захирлын Үүрэг Гүйцэтгэгч Батбилэгийн Золбоог Гүйцэтгэх Захирлаар 2024 оны 5 сарын 1-ээс эхлэн **ТОМИЛСУГАЙ.**

ДАРГА



Ч.ГАНХУЯГ

2024 он 04 сар 25 өдөр

№. 24/08

Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Авлагыг хувьцаанд хөрвүүлэх тухай

Компанийн тухай хуулийн 76-р зүйл, Компанийн Дүрэм болон 2024 оны 4 сарын 25-ны Ард Санхүүгийн Нэгдэл ХК (цаашид “Компани” гэх)-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ээлжит хурлын шийдвэрийн дагуу

ҮНДЭСЛЭХ НЬ:

- Дор гарын үсэг зурагч нь Төлөөлөн Удирдах Зөвлөлийг төлөөлөн энэхүү тогтоолд гарын үсэг зурж, баталгаажуулах бүрэн эрхтэй болохыг **ТЭМДЭГЛЭН**;
- Улаанбаатар Үнэт Цаасны Бирж ХК (цаашид “Бирж” гэх) нь Компанид 1,000,000,000 төгрөгийн өртэй болохыг **ТЭМДЭГЛЭН**;
- Компани нь Биржийн шинээр гаргах 50,000,000 ширхэг энгийн хувьцааг 20 төгрөгөөр тооцон дээр дурдсан өрөндөө хөрвүүлэн авах хүсэлтэй болохыг **ТЭМДЭГЛЭН**;
- Бирж нь нийт 5,000,000,000 зарласан энгийн хувьцаатай бөгөөд энэхүү тогтоол гаргах өдрийн байдлаар нийт 477,549,700 ширхэг гаргасан энгийн хувьцаатай болохыг **ТЭМДЭГЛЭН**;
- Дээр дурдсан Биржийн гаргасан 477,549,700 ширхэг энгийн хувьцаа болон шинээр гаргах 50,000,000 ширхэг энгийн хувьцааны нийлбэр дүн нь 527,549,700 ширхэг энгийн хувьцаа (цаашид “Нийт хувьцаа” гэх) болохыг тус тус **ТЭМДЭГЛЭЖ**,

ТОГТООХ НЬ:

- Биржийн 1,000,000,000 төгрөгтэй тэнцэх өрийг тус биржийн шинээр гаргах 50,000,000 ширхэг энгийн хувьцаа (Нийт хувьцааны 9.4777 хувь)-нд хөрвүүлэн авах саналыг Биржид **ГАРГАСУГАЙ**;
- Бирж нь дээр дурдсан саналыг зөвшөөрсөн тохиолдолд 50,000,000 ширхэг энгийн хувьцааг шилжүүлэн **АВСУГАЙ**;

3. Энэхүү тогтоолд заасан хувьцаа худалдах, худалдан авах ажиллагаанд холбогдох гэрээ болон бусад баримт бичигт гарын үсэг зурах бүрэн эрхийг Гүйцэтгэх захирал Б.Золбоод **ОЛГОСУГАЙ**.

ДАРГА  Ч.ГАНХУЯГ